



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/155

Баруун-Урт сум

Тусгай зөвшөөрөл сунгах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 10 дугаар зүйлийн 10.1.3, 10.1.5, 12 дугаар зүйлийн 12.1, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баруун-Урт сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй С.Ууганболор захиралтай “Бадмаараг өсөх” ХХК-ний “Бадмаараг-1” хүнсний дэлгүүр, Сүхбаатар сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй О.Дуламсүрэн захиралтай “Хайлааст аз хур” ХХК-ний “Аз хур” хүнсний дэлгүүр, Дарьганга сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Д.Мөнхнасан захиралтай “Дэлгэрэх зул” ХХК-ний “Дэлгэрэх” хүнсний дэлгүүр, Эрдэнэцагаан сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Г.Жаргалсайхан захиралтай “Гэрэлт зам молор эрдэнэ” ХХК-ний “Молор-Эрдэнэ” хүнсний дэлгүүр, Дарьганга сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Бат-Очир захиралтай “Оргих-Эх” ХХК-ний “Оргих” хүнсний дэлгүүр, Халзан сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Ө.Батхүрэл захиралтай “Бидний хишиг” ХХК-ний “Бидний хишиг” хүнсний дэлгүүр, Уулбаян сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй О.Мөнхтамир захиралтай “ИХ цагаан нуур” ХХК-ний “Өгөөж” хүнсний дэлгүүрийн согтууруулах ундаа худалдах, Баруун-Урт сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа буй Ч.Зоригтбаатар захиралтай “Асгат хөтөл” ХХК-ний “Эрхэс” зоогийн газар, караоке, Түвшинширээ сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Э.Уранчимэг захиралтай “Их орлой” ХХК-ний “Ая” Зоогийн газрын өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай сунгасугай.

2. Тусгай зөвшөөрөл сунгагдсан болон шинээр олгогдсон аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Х.Энхцэцэг), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Гантулга), Мэргэжлийн хяналтын газар (О.Балжинням), Стандарт хэмжил зүйн хэлтэс (Д.Эрдэнэбат), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийг мөрдөн ажиллахыг дээрх аж ахуй нэгжүүдийн захирлуудад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ